

**МОНГОЛЫН ТӨР, НИЙГМИЙН ЗҮТГЭЛТЭН,
ЭРДЭМТЭН ЗОХИОЛЧ**

Ж.Болдбаатар

Монгол Улсын Их Сургууль. Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль. Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Монголын төр, нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэн, зохиолч Дондогийн Цэвэгмидийн амьдрал, үйл ажиллагааны хөргийг архивын баримт, дуртгал, дурсамжинд тулгуурлан гаргасан болой.
Түлхүүр үг: Сурагч, оюутан, багш, зохиолч, ректор, төрийн зүтгэлтэн

Өгүүлэх ину: Энэхүү өгүүлэлийг чадан ядан тэрлэгч миний бие сайхь эрдэмтэн зохиолчоор хичээл заалгаж явсангүй, насны зөрөө, зэрэг зиндаанаасаа болж, ойртож нөхөрлөж байсангүй. Харин энэ профессорыг МУИС-ийн захирал байхад оюутан ахуй цагаа өнгөрөөж, мөн нэг хэсэг удирдлагад нь багшилж, үг сургамжийг нь сонсож явсан бүлгээ. Харин Д.Цэвэгмид багштай нүүр тулан гурван удаа уулзсан бөгөөд эхний хоёр учрал миний өдий зэрэгт хүрэх их замын гарааг тавьж өгсөн билээ.

Уулзалт- I. Би 1967 онд Булган аймгийн төвийн 10 жилийн дунд сургуулийн X анги төгсөөд, түүхийн мэргэжлийн хуваарь ирээгүй учир МУИС-ийн хэл уран зохиолын ангийг сонгон авсан юм. Учир нь манай түүхийн багш Д.Хорлоо энэ хуваарийг түүхийн ангиар солиход хялбар хэмээн зөвлөсөн билээ. 1967 оны VIII сарын эхээр Улаанбаатарт ирээд хуваариа түүхийн ангиар солих санаатай нэг, хоёр өдөр эргэлдсэн боловч бүтэх янзгүй, гэтэл толгойд УИС-ийн захиралд өргөдөл бичих санаа орж ирэв. Чингээд захиралын албан тасалгааг заалган очтол, урт үстэй, эелдэгхэн зантай сайхан эгч угтав. Ээрч мууран учраа хэлэхэд тэр эгч намайг Д.Цэвэгмид захирал руу дагуулан орсон юм. Захиралын нарийн бичгийн дарга Д.Пагважав гуай байсныг хожим мэдсэн билээ. Би аяархан мэндэллээ. Захирал ч хариу мэнд мэндэллээ. Өргөдөлийг минь уншиж үзсэнээ хүссэн ангид минь оруулахаар цохоод:

- За, хүү минь сайн түүхч болоорой гэж хэлээд, өргөдлийг надад өглөө. Тэр цагийн Цэвэгмид захиралын түмэн амгалан нигуур, номын хүний сүрлэг сайхан төрх намба одоо ч тэр хэвээрээ нүдэнд тусч, сэтгэлд бууж байдаг юм.

Уулзалт II. 1971 онд МУИС төгслөө. Цэвэгмид захиралаас улаан диплом гардан авлаа. Тэр хүний итгэлийг даалаа. Тэнхимдээ багшаар үлдэх боллоо. МУИС-ийн багшаар ажиллуулах ректорын тушаал гараад хоёр хонож байтал

намайг Намын Төв Хорооны үзэл суртлын хэлтсийн орлогч эрхлэгч Ж.Роозон гуай дууджээ. Би пропускын товчооноос зөвшөөрөл авч орлоо. Засгийн газрын ордонд анх удаа хөл тавьж буй хэрэг. Ямар ч сүрмээр юм, хивс нь хүртэл бамбалзууд... Намайг Булган аймгийн Намын хороонд лектороор очиж, ажилла гэлээ. Би багшлах болон эрдэм шинжилгээний ажил хийх сонирхолтой гэдгээ хэллээ. Тэгтэл нам залуу гишүүндээ анхныхаа даалгаврыг өгч байна. Маргааш ирж томилолтоо аваарай гэж хэлээд гаргав. С.Пүрэвжав, Э.Чимэдцэрэн багш нартаа ийм явдал боллоо гэж хэлтэл Ж.Батмөнх проректор дээр ор гэв. Проректортой уулзтал Намын Төв Хороо ингэж шийдсэн бол одоо нэмэргүй, одоо явах л болж дээ гэлээ. Аврал алга бололтой. Проректорын өрөөнөөс гараад ректорын нарийн бичгийн дарга Д.Пагважав гуайд байдлаа хэлтэл, Цэвэгмид ректор одоохон ирнэ, түүнтэй уулз гэв. Удалгүй ректор ирэв. Пагважав гуай миний байдлыг учирлалат өрөөндөө орж, Роозон дарга руу утасдан, мэнд мэдэж энэ тэрийг ярьж байгаад "Бид хэдэн жил сургасан юм, ганц багш мэдэж авч болно биз дээ" гэж хэлээд утсаа тасаллаа. Тэр үед Цэвэгмид багш МАХН-ын Төв Хорооны гишүүн, АИХ-ын даргын сонгууль хүлээж байв. Тэгээд Цэвэгмид захирал нар руу багш хүний шавьдаа итгэл хүлээлгэсэн хийгээд эцэг хүний хайрлан энэрсэн зөөлөн харцаар харж:

- За хүү минь, сайн багш болоорой гэж өрөөгөөд гаргав. Ингэж л би МУИС-ийн багш хэмээх эрхэм хүндтэй албыг хаших болсон юм. Миний амьдралын эгзэгтэй үед түшиг тулгуур болж, өөрийнхөө гайхамшиг амьдрал, уран бүтээл, төв эрхэмсэг намбаараа зөвхөн надад төдийгүй нэгэн бүхэл бүтэн үеийнхэнд багш хэмээн хайрлан хүндлэгдсэн хүн бол профессор Дондогийн Цэвэгмид абугай яах аргагүй мөнөөс мөн бүлгээ.

Уулзалт-III. Багш, шавь хоёр давааны өвөрт ч нэг уулзана, ард ч нэг уулзана хэмээх мэргэн үг бий. 1990 оны IV сард хуралдсан МАХН-ын Онц их хурлаас байгуулсан Ю.Цэдэнбалыг тойрон хүрээлэгчдийн үйл ажиллагаанд улс төрийн үнэлэлт, дүгнэлт өгөх комисс уг асуудалд нэр хамрагдсан хүмүүстэй нэг бүрчлэн уулзахад Д.Цэвэгмид багштай гурав дахиа нүүр тулж нэлээд өргөн хүрээтэй ярилцсан юм. (2)

Профессор Д.Цэвэгмид хуучин тогтолцооны үед өдрийн тэмдэглэл хөтлөн, дуртгал, дурсамжаа бага багаар бичиж үлдээж байсан хуруу дарам цөөн зүтгэлтний нэг юм. Үүнийг Төрийн шагналт, яруу найрагч Д.Нямаагийн эмхтгэн, хэвлэлд бэлтгэсэн "Эргэн санахад" (Дурсамж, тэмдэглэл), (УБ.2005) номноос

бүрнээ үзэж болно. Энэхүү өгүүлэлийн эхний хэсэг гол төлөв “Эргэн санахад” номны баримт сэлт тулгуурласныг тэмдэглэе. Ер нь хуучин тогтолцооны үед түүхийн амьд гэрчийн дуртгал, дурсамжийг төдий л ойшоодоггүйгээр барахгүй хэрэв бичвэл ангич, намч суурь баримтлахыг шаарддаг байсан юм. Цэвэгмид багшид дээрх дурсамжуудыг бичихэд бас л багагүй зовлон тохиолдож байсан бололтой. Тухайлбал, тэрбээр “Дурсамжаа бичээд эхлэхэд өөрийнхөө л тухай өгүүлсэн утга давамгайхан гарч ирэх нь сэтгэл зовмоор” (1,4) хэмээн зовнин өгүүлж байжээ. Түүнчлэн өөрийн дурсамж, дуртгалаа бичлээ гэж Ю.Цэдэнбал даргаас “донго” хүртэж байсан байна. Ийм учраас түүний хуучин тогтолцооны үед бичсэн дуртгал, дурсамжид үзэл суртлын хяналтаас болж, Монголын түүхэнд холбогдох олон нарийн нандин зүйл орхигдсон буй. Харин Ю.Цэдэнбалын “тойрон хүрээлэгчид”-тэй уулзсан ярилцлагад Цэвэгмид багшийн амьдралын олон нарийн ширийн зүйлийн учир холбогдол тодорсон юм. Энэ бүхнээс улбаалан Монголын төр, нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэн, зохиолч энэ хүмүүний амьдрал, үйл ажиллагааны хөргийг архивын сан хөмрөг, хүмүүсийн дурсамж, дуртгал, өөрийн бичиж үлдээсэн өв дээр үндэслэн гаргахыг оролдсон болой.

Бага нас, багшлах ажлын гараа. Хөхөгчин туулай жилийн хаврын тэргүүн сар (1915 оны III сар), Сэцэн хан аймгийн Ачит бээсийн хошууны нутаг Мойлт (Одоогийн Дорнод аймгийн Баяндун сум) хэмээх газар Дондогийн эхнэр нярайлж, нэгэн хөвүүн мэндэлсэн нь Цэвэгмид байлаа.

Тэрбээр малчин удмын багачуудын нэг адил бага насаа өнгөрөөжээ. Сургуульд орохоосоо өмнө өвөл цагт өглөө үдэш аавыгаа даган явж, малдаа өвс өгөлцдөг, дэвсэх хагд хадалцдаг, ээжтэйгээ хамт үхрийнхээ хөлдүүсийг хавчиг хашаанд ханаруулан овоолдог, зуны цагт хонь хариулдаг, хонины арьс халимлах, идээлэх, гадсанд мушгих, хэдрэгдэх, элдсэн арьсыг утах, утаарь малтах зэргээр эхдээ тусална. Долоо настайгаасаа эхлэн аавтайгаа хадланд гарч, хадуураар өвс хадахыг заалгаж эхэлжээ. Үүний зэрэгцээ зэрлэг зөгийн бал хурааж, хүнс тэжээлдээ нэмэрлэнэ.

Д.Цэвэгмид арав шүргэж 1925 онд Хэнтий аймгийн Улз голын хошууны бага сургуульд орж, “А” үсэг заалган, эрдэмд амалж эхэлжээ. Сургууль Наранбулагийн горхины зүүн эрэг дээр нутгийн дархцуулын барьсан хоёр дүнзэн байшинд байрлана. Гол хичээл нь монгол бичиг, тоо бодлого, дэлхийн байдлын тухай. Хичээлийнхээ гадуур оройн цагаар сургуулийнхаа танхимд очиж, хичээлээ

давтахын хамт дуу, жүжгийн дугуйланд суралцана. Цэвэгмид хүү "Лхасарай, Долгор", "Жигдэн ноён" зэрэг жүжгийн хүүхдийн роль тоглодог, бас туулайн баг өмсөөд "Борхон туулай" шүлгийг тайзан дээрээс уншихад үзэгчид баясан сонсдог байжээ.

Д.Цэвэгмид Улз голын бага сургуульд гурван жил суралцан төгсчээ. Чингээд Нийслэл хотноо ирж, Багш нарыг бэлтгэх сургуулийн оюутан болов. Чөлөө авч гэртээ хариад Улз голын хошуунд бичээчийн албыг түр хашиж байв. Тэгээд сургуульдаа эргэж ирэв. Залуу хөвгүүн шамдан хичээллэж II ангид суралцаж байтал багшлах боловсон хүчин дутагдалтай байсан учир 1930 оны III сард Улаанбаатар хотын Хар бологсдын бэлтгэл сургуульд түмэн бодисын багшаар томилсон байна. Тэр үед Цэвэгмид дөнгөж 15 настай байлаа. Эл сургуульд жил хагас ажиллахдаа "Амьгүй бодис", "Амьд бодис", "Наран саран хиртэхийн учир" зэрэг конспект боловсруулж, олон хувь олшруулан сурагчиддаа гарын авлага болгон өгч байсан аж.

Залуу багш Цэвэгмид 1930 зун жүжигчин болох шахжээ. Нэрт зохиолч Д.Намдаг: "Би Дондогийн Цэвэгмидийг жүжигчин болгох гэж театрт дагуулж аваачин шалгуулж байсан юм. Цаадах чинь тэнцсэн боловч хөдөө ажлаар явчихаад олдоогүй" (3) хэмээн дурсан ярьсан байдаг. Түүний хувь заяа багшлах одонд тохиожээ. Ардыг гэгээрүүлэх яам залуу Цэвэгмидийг 1931 оны VIII сарын 15-нд Дөрвөд аймгийн төвийн аж ахуйн сургуульд багшаар томилсон байна. Тэрбээр Баруун аймгийн 50-иад багштай хамт Нийслэл хотоос гараад морин өртөө дамжин морь, үхэр тэрэг, зарим газар тэмээгээр аялан явсаар 45 дахь хоног дээрээ Улаангом оржээ. Тэрбээр хожим энэ тухайгаа дурсахдаа: "Өртөөнийхөн ачааг үхэр тэргээр, элчийг мориор явуулдаг байлаа. Элч нарын дунд би хамгийн бага нь (16 настай) байсан учир "Чи давхиж чадахгүй, бидний явдалд саад болно. Ачаагаа харж, тэргээр яв гэдэг сэн. Тэгээд би үхэр тэрэг дагаж, голдуу явган явдаг байлаа" (1,10) гэж бичсэн байна.

Алс баруун аймагт томилогдож ирсэн залуу хөвүүнийг 8 эсгий гэртэй, гол төлөв сахиус зүүсэн, гээг үстэй 40-өөд сурагчидтай сургууль угтав. Аж ахуйн сургууль нэртэй сурагчдын их зонхи нь өөрөөс нь ах, тэр ч байтугай тэдний дотор 50 шахам насны сурагч байв. Сурагчид хир буртаганд баригдсан "биеэ угаавал буян арилна" гэсэн мунхралд автсан, тэр бүү хэл бөөс хуурсандаа баригдсан нэгэн ч байлаа. Ийм нөхцөлд багш хичээл заахын зэрэгцээ тэднийг усанд оруулна,

өвдвөл эмчилнэ, ухуулга таниулга хийж бүжиг наадам заана. Биеийн тамир, спортын тэмцээн явуулна.

Д.Цэвэгмид “Түмэн бодис”, “Дэлхийн байдал”, “Латин үсэг”, “Тоо бодлого” гэх зэрэг олон төрлийн хичээл заана. Бас уран зохиолын бүлгэм байгуулж, “Өнчид”, “Харгис хөрөнгөтөн” зэрэг драмын жүжиг, дуулалт жүжиг зохиож Дөрвөдийн Үнэн зоригт ханы ордонд тоглуулж байжээ. Залуу багш орчин цагийн шинжлэх ухааны ололтыг аль болохоор хичээл, лекцэндээ ашиглах оролдлого хийж байв. Тухайлбал, карбит кальцаар гэрэлтүүлдэг аппаратаар диапозитив үзүүлэн, эртний үлэг гүрвэлүүдийн тухай, дэлхийн бөмбөрцөг хэрхэн эргэлддэг тухай ярьж таниулна. Үүнийгээ аймгийн клубт уншдаг лекцэндээ ашиглана. Хэрэг дээрээ энэ нь кино маягийн үзвэр байв. Дөрвөд аймгийн төвийн аж бага сургууль тэр үеийн хамтралын ажилтнуудыг бэлтгэж байсан учир Цэвэгмид багш Баруун турууны голд сурагчидтайгаа очиж, газар хагалж, тариа тарих дадлага хийдэг байжээ. Д.Цэвэгмид энэ нутагт байсан тухайгаа дурсан бичихдээ: “Сургуулийн нярав Байтуу үлээсэн давсаг мэт бөөрөнхий ногоо авчирч өгснийг идэхэд амттай гэдэг нь жигтэйхэн, анх удаа ийнхүү арбуз буюу шийгуа гэгчийг идэж билээ. Аав, ээж, гэр орноосоо алс хол явахад ийнхүү элэгсэг найртай угтаж, орох орон, ор дэр, хоол унд бүгд бэлэн, халамж анхаарал төгс байсанд арван хэдхэн настай балчир хөвгүүд бид их л урам зоригтой байж билээ. Ер нь Увс нутгийнхан ааш зан сайтай, найрсаг зочломтгой, очсон айл, уулзсан хүн болгон “Бичкан хөвгүүн аль нутгийнх вэ?”, “Хөвгүүн хэдэн настайв ч”, “Гэрээ санаж байна уу, хөвгүүн?” гэх зэргээр асууж танилцан, настан буурлууд нь “Көөрхий бичкан хөвгүүн байна” гэж толгой илж өхөөрдөхөд нь сэтгэл уяран баярладаг” (1,76) байснаа тэмдэглэжээ.

Чингэсээр Д.Цэвэгмид 1932-1933 оны хичээлийн жилийг баруун хязгаар нутагт эхлүүлжээ. Зав зайндаа Холбооны Очирбат хэмээх хүнээр орос хэл заалгана. Д.Цэвэгмид өөрийн хүсэлтээр Улаанбаатар хотноо шилжиж ирээд Ардын гэгээрүүлэх яамны сайдын тушаалаар бичиг үсгийн түр курст багшилж, латин үсэг, тоо бодлого, түмэн бодисын хичээл заах болов. Эл курсыг төгсөгчид хөдөө орон нутагт бичиг үсгийн багшаар томилогдон ажиллана.

Эл курст нэг жил багшилж байтал 1933 оны VIII сарын 1-нд Д.Цэвэгмидийг Рабфакийн бэлтгэл сургуульд түмэн бодис, тооны багшаар томилжээ. Энэ сургууль Нийслэлийн Усны гудамж хавьд байсан бөгөөд Буриадын Улаан-Үд хотод

рабфакт явж суралцах хүмүүсийг бэлтгэдэг байв. Энэ сургуульд 1935 оны VIII сар хүртэл ажиллахдаа сүүлийн нэг жил захирлаар нь ажиллаж байв.

Д.Цэвэгмидийг 1935 оны VIII сарын нэгнээс Дорнод аймгийн төвийн дунд сургуулийн багшаар томилжээ. Тус сургуульд ургамал судлал, амьтан судлал, физик, хими, тоо бодлогын хичээл заав. Бараг бүх байгалийн ухааны хичээл заах үүрэг хүлээжээ. Цэвэгмид зааж байгаа хичээлүүдээрээ кабинет байгуулж, аймгийн төвийн албан хаагчид, сурагчдад лекц уншихдаа электрофор машинаар цахилгаан оч гаргаж, тэнгэрийн дуу, цахилгааны учрыг тайлбарладаг, химийн бодисуудаар урвал үзүүлж, шашны мунхруулгын эсрэг ухуулга таниулга хийдэг байсан байна. Сурагчдын дунд биеийн тамир, уран зохиол, ший жүжгийн дугуйлан ажиллуулна. Энэ үед Д.Цэвэгмид дөнгөж 20 шүргэж байсан боловч хэзээний туршлагатай багш болжээ.

Уранзохиолд оюун билэг, хүчээ сорьсон нь. Залуу хөвгүүн Цэвэгмид 1930 онд уран зохиолын бүлгэмд бүртгэгдэж, Дөрвөд аймагт багшлах үеэсээ уран зохиол сонирхон оролдож эхэлжээ. Тэрбээр: "1931 оны VIII сарын 20-нд Улаанбаатараас гараад 45 дахь хоног дээрээ Дөрвөд аймгийн төв хүрсэн аян замын тэмдэглэлийг нэлээд дэлгэрэнгүй бичиж билээ. Түүнийг одоо сөхөж үзвэл: Зам дагуу үзсэн харсан ой мод, уул ус, амьтныг голчлон тэмдэглэжээ. Мөн хааяа толгой холбон шүлэглэхийг оролдсон хэсэг тохиолдоно" (1, 63) гэж тэмдэглэжээ. Энэхүү тэмдэглэл бол уран зохиолд хүчээ сорих анхны гараа байсан бололтой.

Тэрбээр Дөрвөд аймгийн төвийн аж ахуйн сургуульд багшилж байхдаа "Өнчид" хэмээх богино хэмжээний шүлэглэсэн жүжиг зохиосон байна. Эл зохиолд хадам харьд богтлогдсон нэг ядуу бүсгүйн амьдралын зовлонг шүлэглэн өгүүлсэн бөгөөд эцэст нь сайхь бүсгүй доромжлол, харгислалыг тэвчиж чадалгүй эргийн ганц хайлаасанд боож үхснийг үзүүлжээ. Энэ жүжгээ тайзан дээр амилуулж байсан байна.

Д.Цэвэгмид Дөрвөд аймгаас 1932 оны намар буцаж ирээд уран зохиолчдын бүлгэмд дахин орж, 1935 он хүртэл хичээллэжээ. Түүний сан хөмрөгт хадгалагдаж байгаа зүйлийн дотор "Туйлаас баярламуй", "Сүх жанжин", "Хэрээний савар", "Өлссөн барс", "Цэлмэг өдөр урамдах буга", "Туулын голын тунгалаг усанд биеэ сэрүүцүүлэх зуураа түүний хөвөөнд бас нэг гайхамшигийг үзвэй", "Цагаан бороо", "Хөгшин хайлаас", "Хуш мод" зэрэг шүлэг, өгүүллүүд байгаа нь 1932-1935 онд уран зохиолчдын бүлгэмд суралцаж байсан үеийнх бололтой. Энэ завсар С.Буяннэмэх,

Ц.Дамдинсүрэн, Д.Нацагдорж, Н.Наваан-Юндэн, Өөлдийн Чимэд, М.Ядамсүрэн, Ши.Аюуш, Л.Цэрэн-Очир, Б.Ишдорж, П.Хорлоо, Б.Содном, Б.Доржсүрэн зэрэг зохиолчидтой танилцжээ. Зохиолчдын бүлгэм долоо хоног бүр хичээллэж, тав, арван минутын дотор шүлэг зохион уншиж хэлэлцүүлдэг байв. Энэ бүлгэмд шүлгээ хэлэлцүүлж байсан тухайгаа Цэвэгмид багш дурсахдаа: “1933 оны намрын нэг хичээл дээр “Хайран хамар” гэдэг шүлгээ уншихад минь бүлгэмийн хичээлд суугчид хоорондоо инээлдэн “Энэ хүүхэд бас ийм юм бичнэ ээ” гэсэн шиг хошин байдалтай байв. Тэгэхэд Д.Нацагдорж дув дуугүй, толгойгоо баахан хазайлган сууж байсан билээ. Миний бичсэн тэр шүлгийг зарим зохиолч “ингэж шууд илээр бичиж болдоггүй юм” гэж шүүмжлэв... Нэлээд хэдэн хүн ярьсны дараа Д.Нацагдорж надад хандаж “Чи хэдэн настай вэ?” гэж асуугаад... энэ шүлэг чинь зүгээр болжээ. Гэхдээ засмаар юм байна. Ер нь бичсэн зохиолоо дахин дахин уншиж хянаж, улам улам сайжруулж байх хэрэгтэй” гэж сургамжилсныг санаж байна” (1,57) хэмээн бичжээ. Түүнчлэн уран зохиолын бүлгэмд С.Буяннэмэх, Б.Ишдорж зэрэг хүмүүс оролцож, зөвлөж сургадаг байсан аж. Уран зохиолчдын бүлгэмийн хичээл дээр бичиж эхэлсэн “Хадлангийн өглөө”, “Хэрлэн гол”, “Эрдмийн хаалга нээгдэв”, “Дөрвөн цаг”, “Улз гол”, “Эхний цас”, “Хамхуул”, “Үнэг” зэрэг шүлгүүд нь бичмэл эхээрээ хадгалагдаж байна. Жишээ нь:

“Хадлангийн өглөө” шүлэг

“Хээрийн салхи сэржигнэн сэржигнэн үлээж

Өвсний толгой найган найган ганхаад

Өндрийн цаанаас алтан наран мишээж

Өргөн талбайд мөнгөн дусал гялтганана

Хадах ногоо намиран намиран бөхөсхийж

Хадуур машин хангинан жингэнэн эргэлдээд

Атрын өвс эвхрэн эвхрэн хураагдаж

Агаарын сайханд ажиллах зориг бадраана”

“Хэрлэн гол” шүлэгт:

“Урсаж байх нь дөлгөөн сайхан

Ундарч байх нь баялаг сайхан

Агаар салхи урьхан сайхан

Аяны зам нь шулуун сайхан

Эргийн цэцэг нь элбэг сайхан
Эргэх шувууд нь үзэсгэлэн сайхан
Уухад ус нь ариун сайхан
Умбахад урсгал нь сэрүүн сайхан хэмээн бичжээ.

Мөн 1932 онд “Агуу мандмал багшийн сургууль” гэсэн үгтэй алдартай дууныхаа үгийг зохиож, их Нацагдоржид үзүүлж, “зүгээр” гэсэн үнэлгээ авч байсан байна. Д.Цэвэгмидийн төрөлхийн авъяас билгийн аргамж алдууран, уран зохиолын замд хурдан өсч, “Хоньчин Найдан”, “Болд, Самбуу”, “Сурагч Ганбат” хэмээх алдарт өгүүллэгүүдээ жинхэнэ амьдралаас сэдэвлэн туурвижээ. Түүний “Булшин дээр” хэмээх найраглал олны танил болсныг бид мэднэ.

Д.Цэвэгмид Дорнод аймгийн төв Баянтүмэнд уран зохиолчдын хөдөөгийн анхны салбар бүлгэмүүдийн эхийг тавьжээ. Тус бүлгэмд суралцаж байсан Монгол Улсын Соёлын гавъяат зүтгэлтэн, сэтгүүлч “Өвгөөдэй” хэмээх Ц.Дамдинсүрэн: “Дугуйлан утга зохиол сонирхогч, албан хаагч, багш сэхээтэн 13 хүн хичээллэж байсан бөгөөд багш маань Дондогийн Цэвэгмид байжээ.

Багш Цэвэгмид уран зохиол гэгч юун, түүний төрөл зүйл, зохиол бүтээлд хуучин уран зохиол ба ардын аман зохиолын өв нөлөө, түүнийг хэрхэн тунгаан хэрэглэх арга зам тэргүүтнийг тусгай хөтөлбөрөөр заана. Бас Орос, Зөвлөлтийн болон гадаад уран зохиолын байдлаас сонсгоно.

... Олон сайхан шүлэг, найраглал, өгүүллэг, туужсаараа нэрд гарсан зохиолч эрдэмтэн Дондогийн Цэвэгмид тэр үед дугуйлангийн багш гэж биеэ тоохыг огоот цээрлэж, өөрийн бичиж зохиосныг нөхөддөө уншиж, үг сэлбэгийг дуртайяа угтан сонсож, угийн хүүхдэрхэг зангаар нүүрээ үе үе ялимгүй улайлгаж талимааран сууж байсан нь, түүний цаашдын зохиол бүтээлийн чанар чансаанд тус болсон байж ч юун магад гэж боддог” (4) гэж дурсан бичжээ.

Д.Цэвэгмид уран зохиол сонирхон оролдохын зэрэгцээ орос хэлнээс ном орчуулах ажилд шамдан орсон байна. Тэрбээр үлгэр жишээ дунд сургуульд болон Багш нарыг бэлтгэх сургуульд багшилж байх үедээ Всесвятскийн “Ургамлын судлал” хэмээх номыг орчуулахаар Ардыг гэгээрүүлэх яамтай гэрээ хийж, орчуулах ажлын гараанд гарчээ. Энэ тухайгаа Цэвэгмид багш: Бурдуковын Орос-Монгол толийн тусламжтайгаар үг болгоныг нэгд нэгэнгүй үзэх журмаар орчуулсан тухай дурсан бичсэн байдаг. Дараа нь “Хүний үүсэл”, “Амьдралын үүсэл” зэрэг

жигжиг товхимолууд, А.Д.Симуковын “Монгол орны газар зүй” номуудыг тус тус орчуулжээ. Цэвэгмид багш ийм маягаар нөр хичээнгүй ажиллаж байж орос хэл сурсан байна.

Улс төрийн хэлмэгдүүлэлтэнд өртсөн нь. Д.Цэвэгмидийг Дөрвөд аймагт багшилж байхад эцгийн нь төрсөн ах, дүү нар, мөн хамт сургуульд сурч байсан А.Магсар, А.Намсрай, А.Цэрэн зэрэг олон хүнийг “Лхүмбийн хэрэг” гэгчид холбогдуулан баривчилжээ.

Д.Цэвэгмидийг Баянтүмэнээс ирээд нутагтаа очиход буриад удам гарвалтай бүхнийг баривчилсаар байлаа. Тийм хүнд үед л буриад зон аргаа барахдаа:

Тэнгэрийн бүрхэгийг гийгүүлсэн

Тэнүүн шар наран байна

Тэнэг буриадуудыг гэгээрүүлсэн

Тэргүүн маршал Чойбалсан байна

Огторгуйн бүрхэгийг арилгасан

Очтой хурц наран байна

Олиг муутай буриадуудыг сэнхрүүлсэн

Одонтой маршал Чойбалсан байна (5) гэсэн дуу гаргачихсан дуулж байсан тухай Д.Цэвэгмид багш дурсан ярьж байсан юм. Гэтэл буриад эрчүүдийг олноор барьж, ачсаар байжээ.

Д.Цэвэгмидийг 1937 оны үед эсэргүү нарын гэр бүлийн хүн гэж үзээд Багшийн сургуулийн багшаас халж, Соёлын ордны номын сангийн ажилтан болгожээ. Гэвч мэргэжилтэн ховор байсны учир үлгэр жишээ дунд сургуулийн багш, зөвлөлтийн мэргэжилтэн Камешковын дагалдан буюу орчуулагчаар ажилласанаар орос хэлнийхээ чадварыг дээшлүүлж, улмаар уран зохиолын онол, мэдлэгийн нь цар хүрээ тэлсэн байна.

Д.Цэвэгмид багшийг улс төрийн хэлмэгдүүлэлтийн хар шуурга тойрон өнгөрсөнгүй. Түүнийг 1939 оны IV сарын 18-нд Соёлын ордонд болсон багш нарын хурал дээр зарим хүн тухайлбал, Цэдэв: (Хожим Дотоод яамны сайд болсон) Цэвэгмид буриад, эсэргүүний үр сад, Сургуулийн захирал байхдаа хоёр шуудай төмс ялзруулсан гэж шүүмжилжээ. Гэтэл хурал тармагц түүнийг баривчилсан байна. Эхлээд шоронгийн хоригдлууд таатай хүлээж авсангүй, дээрэлхэх янзтай. Гэвч хэд хоногийн дараа байдал эрс өөр болжээ. Энэ тухай тэрбээр: “Шоронд дүүрэн хүн байсан. Сүүлдээ танилцаж, зовлон жаргалаа хуваалцаж эхэлсэн. Би

тэдэнд “Наян мянган километр усан доогуур”, “Арван таван наст капитан”, “Дикмарен”, “Хөх Монголын хөх туг” зэрэг зохиолуудыг хоригдлуудад ярьж өгнө. Тэд амаа ангайн амтархан сонсоно. Хоол ирэхэд хамгийн түрүүн надад өгнө. Зохиолоо үргэлжлүүлэн ярихад зарим үед инээлдэнэ. Хуягууд уурсан хашгирч, чимээгүй байхыг шаарддаг байлаа. Нэг удаа хаалганы хоол өгдөг цонхоор буудсан удаа ч гарсан” (5) хэмээн дурсан ярьсан юм. Түүнийг гол төлөв Сайнжаргал хэмээх хүн байцаана. Эхлээд сургуулийн хүүхдийн идэшний төмс ялзруулсан хариуцлагагүй этгээд хэмээн загинаж байснаа сүүлдээ хорлон сүйтгэгч гэсэн ял тулгаж байлаа.

Д.Цэвэгмидийг сар орчим шоронд хориод суллажээ. Шоронд орохын өмнө тэрбээр МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдэд “Дарвинизм” заадаг байсан аж. Гэтэл багш нь ирэхээ больчихоор яачихав, ийчихэв гэсэн яриа болжээ. Дөнгөж МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга болсон Д.Дамба Цэвэгмидийг сураглахад баривчлагдсан гэсэн хариу өгчээ. Д.Дамба Дотоод яамныханд онц хэрэггүй бол гаргавал яасан юм бэ? гэхэд, хэд хоногийн дараа сулласан байна.

Их сургуультай хувь заяагаа холбосон нь. 1942 оны X сарын 5-нд БНМАУ-д орчин цагийн ууган их сургууль нээгдэв. Яг энэ үед Д.Цэвэгмид тус сургуулийн Зоологийн тэнхмийн лабарантаар орж ажилласан байна. Тэр үеэс Цэвэгмид Их сургуулийн гэсэн алдрыг хүртэж эхэлжээ. Тэрбээр 1945 он хүртэл лаборантаар ажиллахдаа анагаах ухаан, мал эмнэлэг, тоо, физикийн факультетийн хичээлд зав чөлөөндөө сууж шалгалт өгдөг, зуны цагт профессор А.Г.Банников, Э.М.Мурзаев, А.А.Юнатов нарын хамт Алтайн цаадахь говь, баруун нуурын хонхор, Халх Нөмрөгийн голын сав, Хөвсгөл, Завханы нутгаар аялан, их зүйлийг мэдэж авчээ. Уг аялалын нэг хэсгийг Цэвэгмид багш “Алтайн цаадах говьд” хэмээх тэмдэглэлдээ нүдэнд харагдтал дүрсэлсэн буй. Энэ тухайд эрдэмтэн зохиолч Л.Түдэв: “Үгийн яруу сайхнаар байгалийн гоо үзэмжийг зурж үзүүлэхэд хоёр үзэсгэлэн хослон нийлж, хүний сэтгэлийг эзэгнэн авдаг” хэмээн 1974 онд хэвлэгдсэн Д.Цэвэгмидийн “Зохиолууд” номыг хянан нягтлахдаа тэмдэглэжээ. “МУИС-ийн түүхийн товчоон” хэмээх номонд: “Анхны жилүүдэд ЗХУ-ын эрдэмтэн багш нар урилгаар ирж, мэргэжилтэн багшаар ажиллаж байв. Тухайлбал, нэрт эрдэмтэн, амьтан судлаач профессор А.Г.Банников (1942-1948 онуудад), ургамал судлаач, профессор А.А.Юнатов (1942-1948), амьтан судлаач, профессор В.Н.Скалон (1945-1951) нар хичээл заахын зэрэгцээ Монгол орны

амьтан, ургамлын аймгийн судалгааг хийж, оюутан залуучуудыг дагалдуулан сургаж байлаа” (6,90) гэж тэмдэглэсэн байна. Тэдний нэг нь Цэвэгмид багш байв.

Д.Цэвэгмид 1945 оны намар-Ялалтын намар Москва хотын Ломоносовын нэрэмжит улсын их сургуульд суралцах ховорхон аз тохиов. Тэрбээр эрдэм номын энэхүү их өргөөнд цаг мөч тутам танин мэдэхүйн баяслыг амсч, оюун ухаанаа тэлж, хурцалж байлаа. Эрдэмд шамдан суралцахын хамт судалгааны ажлаа үргэлжлүүлсээр ...

Москвагийн их сургуульд суралцаж, төгсөх дөхөж байх үед нэгэн сонин зүйл тохиолдсоныг МАХН-ын Онц их хурлаас байгуулсан Ю.Цэдэнбалыг тойрон хүрээлэгчдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх комиссынхонтой Цэвэгмид багш ярилцахдаа: “Дамдинсүрэн гуай хойно (ЗХУ-д) байсан. Нэг өдөр надад тэрбээр хэлэхдээ: маршал Чойбалсан төрийн сүлд дуу бич гэсэн даалгавар өглөө. Хоёулаа бичье гэсэн. Хоёулаа сар шахуу сууж бичсэн. Одоо ч миний бичсэн бадгууд сүлд дуунд бий. Тухайлбал:

Дархан манай хувьсгалт улс

Даяар Монголын ариун голомт

Дайсны хөлд хэзээ ч өртөхгүй

Дандаа энхжин мөнхжинө гэж би бичсэн. Дамдинсүрэн гуай

үзээд:

- Цэвэгмид ээ, даяар Монгол гэдгийг панмонголизм гэж хэлж магадгүй, энэ ер нь болох уу, үгүй юу, энэ чинь бүх монгол туургатныг хэлж байгаа хэрэг шүү дээ гэхэд би:

- Үнэн нь энэ шүү дээ гэхэд тэрбээр зөвшөөрөөд өөрийнхөө бичсэн бадгуудтай нийлүүлж, нэг болгоод хоёулаа гарын үсэг зурж маршалд явуулсан. Хэсэг хугацааны дараа Дамдинсүрэн гуай:

- Нөгөө сүлд дуу маань болохсо больсон шиг байна. Чамаас боллоо, даяар монгол гэдэг чинь болохгүй болгосон байх гэв. Нэг хэсэг чимээгүй л байлаа. Гэтэл удалгүй сүлд дуулал батлагдаж, үгийг Ц.Дамдинсүрэн, хөгжмийг Мөрдорж, Б.Дамдинсүрэн гэсэн зохиогчидтой гарч ирсэн. Ц.Дамдинсүрэн гуай: Зохиолчдын хорооныхонд хэлсэн гэж байсан. Ямар ч гэсэн ба төрийн сүлд дууны үгийг зохиолцсон хүн гэдгээ хэлье. Би шагнал горьдож хэлж байгаа юм биш шүү. Юм үнэнээрээ байг л гэж ярьж байгаа юм. Намайг баригдаж, тавигдаж байсан, буриад гээд хавчиж хайрах явдал байсан гэдгийг хэлье” (5) гэж ярьж байсан юм.

Д.Цэвэгмид 1950 оны X сард Москвагийн их сургуулийг дүүргэж, нутгийн зүг хөлгийн жолоог залах болов. Хамгийн гол нь сайхь хүмүүн тус сургуулийг төгсөх үедээ “Давхар үүдэн шүдэт мэрэгчдийн амьдрал, биеийн бүтцийг харьцуулан судалсан нь” хэмээх сэдвээр биологийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ. Ийнхүү Д.Цэвэгмид Монголын ууган эрдэмтдийн нэг болж, “хээрийн галуу нисэн үл хүрэх газраас хүний хүү эрдмийг өвөрлөн ирнэ” хэмээх онч мэргэн үгийг бодит биелэл болгосон байна. Энэ тухайд Цэвэгмид багш сонин дурсамж ярьсныг олж сонссон юм. Ц.Дамдинсүрэн гуайг ЗХУ-д аспирантурт сурч байгаад зун ирээд буцахад маршал Чойбалсан өөрийн биеэр нисэх буудал дээр очиж үджээ. Цэвэгмид багш Ц.Дамдинсүрэн гуайтай хамт нисэх гэж байв. Тэрбээр маршалд Цэвэгмид багшийг танилцуулж, Москвагийн их сургуульд сурдаг, бас эрдмийн ажил хийж байгаа тухай ярьжээ. Маршал эл ярианд тун тоомсоргүй хандаж, харин дахин дахин:

- Дамдинсүрэн чи Монголоос хамгийн түрүүнд эрдэмтэн болох ёстой хүн шүү гэж захиж байжээ. Залуу Цэвэгмид маршал надад даалгавар захиас өгөх байх гэж бодож байсан тул тун их гомджээ. Адилхан хоёр залуу хүн эрдмийн ажил хийж байхад намайг үл тоож байна хэмээн гоморхсон хэрэг. Хожим бодоход үнэхээр Дамдинсүрэн гуайг билгүүн номч эрдэмтэн болохыг улс төрийн хашир зүтгэлтэн хүний хувьд сайн мэдэж байсан юм билээ гэж Цэвэгмид багш дурсан ярьж байжээ.

Их сургууль төгсч ирмэгц Д.Цэвэгмидийг МУИС-д хуваарилав. Тэрбээр 1951 оны I сарын 1-нээс 1953 оны I сарын 1 хүртэл Зоологийн тэнхмийн эрхлэгч, Анагаах ухааны факультетийн декан, сургуулийн проректороор ажилласан байна. 1953 оны I сарын 1-нээс 1959 оны VII сарын 1 хүртэл МУИС-ийн ректорын алба хашчээ.

Түүнийг МУИС-ийн ректороор болон удирдлагад ажиллах үед тус сургуулийн зоотехник, мал эмнэлгийн факультетүүд өргөжин хөгжсөөр 1958-1959 онд Хөдөө аж ахуйн дээд сургууль болон бие даасан юм. Мөн 1951 онд хими-биологийн багш бэлтгэх тусгай салбар, улмаар 1956 оноос манж, төвд, англи, франц хэлний анги, 1957 онд театрын найруулагч, агротехникийн анги 1958 онд геологийн анги тус тус нээгджээ. Түүнчлэн энэ үед МУИС багшлах үндэсний боловсон хүчинтэй болсон байна.

Д.Цэвэгмид сургууль удирдахын хамт Биологийн болон Анагаах ухааны факультетэд “Сээр нуруутан амьтны судлал”-аар лекц уншиж байв. Үндэсний дээд

мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд МУИС-ийн оруулсан хувь нэмрийг үнэлж, БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1957 оны X сарын 5-ны өдрийн зарлигаар "Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон"-гоор шагнажээ.

Д.Цэвэгмид 1959-1960 онд Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэнгийн даргаар томилогдсон байна. Энд хоёр жилийн нүүр үзэхдээ ШУА-ийг байгуулах үндсийг бүрэлдүүлэх, шинжлэх ухаан, дээд боловсролын харилцан шүтэлцээг хангахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллаж байв.

БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэх төлөөлөгчдийн тэргүүн. 1960 онд Д.Цэвэгмидийг БНМАУ-ын Гадаад явдлын яамны I орлогч сайдаар томилжээ. Энэ үед түүний үйл ажиллагаа БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэх бэлтгэлийг хангахад голлон чиглэсэн юм. 1961 он X сарын 20-нд Д.Цэвэгмид тэргүүтэй БНМАУ-ын төлөөлөгчид Нью-Йоркийг зорин нисчээ. Москва, Амстердам хотыг дайран ниссээр X сарын 24-нд АНУ-ын Нью-Йорк хотын Айдлуайлд буудалд Монголын төлөөлөгчдийг буухад ЗСБНХУ-ын Гадаад явдлын яамны орлогч сайд, НҮБ-ын дэргэдэх байнгын төлөөлөгчдийн газрын тэргүүн В.А.Зорин нарын хүмүүс угтан авав. Онгоцны буудлаас гадагш гарахыг завдтал сонин, хэвлэлийн сурвалжлагчид бүчин авчээ. Тэдний нэг нь:

- Эрхэм ноёд ямар зорилго, хэргээр АНУ-д ирсэн бэ? гэж асуухад:

Д.Цэвэгмид:

- Нэгдсэн Үндэсний Байгууллагад БНМАУ-ыг хууль ёсны байр суурийг эзлүүлэх асуудлыг НҮБ-ын XVI чуулганаар хэлэлцэх гэж байгаатай холбогдуулан ирлээ гэж товчхон хариулав. Бас нэг сурвалжлагч:

- Өөрийн улсыг НҮБ-ийн гишүүн болно гэдэгт итгэж байна уу? гэхэд тэрбээр:

- БНМАУ, НҮБ-ын гишүүн байх ёстой, Ерөнхий Ассамблейн энэ удаагийн чуулганаар манай улс НҮБ-ын гишүүн болно гэдэгт итгэж байна гэж хариу хэлээд, эрхэм ноёдтой дараа уулзах нь зайлшгүй, яриаг үүгээр төгсгөө. Яарсан явдалдаа өршөөлийг хүсье гээд гадагш гарч, угтаж ирсэн нөхдийн хамт урт гэдгийн хар машинаар Нью-Йорк хот руу явжээ. Маргааш нь зарим сонинд: "Монголын төлөөлөгчид Зөвлөлтийн Элчин сайдын яамны машинд сууж яаран сандран зугтав" хэмээн гуйвуулан мэдээлсэн тухай Цэвэгмид багш МУИС-ийн багш нарын нэг хурал дээр дурсан ярьж байж билээ.

1961 оны X сарын 25-нд Аюулгүйн зөвлөлийн 971 дүгээр хуралдаанаар БНМАУ-ын НҮБ-д гишүүнээр элсүүлэх асуудлыг хэлэлцжээ. Санал хураах

зөвлөлийн 11 гишүүний 9 нь манай улсын төлөө саналаа өгч, АНУ түдгэлзэн, Дундат иргэн улсын төлөөлөгч хуралд оролцоогүй болж, байнгын гишүүдээс хориг тавьсан улс гарсангүй.

1961 оны X сарын 27-ны өдөр Ерөнхий Ассамблейн 1043 дугаар хуралдаан болж тус хуралдаанд ЗХУ, Энэтхэг, Чехословак, Куба, Индонез, Цейлон, Мали, Бирм, Гвиней зэрэг улс төр газар зүйн бүх бүлэглэлийг төлөөлсөн 25 орон БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэх тогтоолын төслийг хамтарч оруулсан байна. Энэхүү төслөөр Ассамблейн дарга, Тунисийн төлөөлөгч Монж Слим санал хураалт явуулсан ч үгүй, бүх төлөөлөгчид нэгэн дуугаар алга ташин хүлээж авчээ. Ийнхүү БНМАУ НҮБ-ын 101 дэх гишүүн болжээ.

Д.Цэвэгмид тэргүүтэй Монголын төлөөлөгчдийг “Монгол” гэсэн хаягтай суудалд урьж суулгав. Танхим дүүрэн нижэгнэтэл алга ташиж, олон улс орны төлөөлөгчид баяр хүргэжээ. НҮБ-ын албан ёсны хэл бол англи, испани, орос, франц, хятад хэл боловч эхний үгийг төрөлх хэлээрээ хэлэхийг чуулганы дарга зөвшөөрсөн тул Д.Цэвэгмид Ерөнхий Ассамблейн хүндэт индэр дээрээс анх түрүүн монгол үг аялгуу хангинан цуурайтаж, энэ өдрөөс эхлэн БНМАУ, НҮБ-ын XVI чуулганы ажилд оролцож эхэлсэн байна. Манайм төлөөлөгчид ажил үүргээ хуваарилахад Цэвэгмид бүгд хуралдаан болон зэвсэг хураах I хороог өөртөө авчээ.

БНМАУ НҮБ-д элссэний дараа залгаж Мавритан улсыг гишүүнд элсүүлэх асуудлыг чуулганаар хэлэлцжээ. НҮБ-ын гишүүнд элсүүлэх талаар Монгол, Мавритан хоёрын асуудал холбоотой болж, БНМАУ-ыг Чан Кайши, Мавританыг Мароккийнхан ча

нгааж, улмаар баруун, зүүний хсёр эвсэл нэгийг нь нөгөөтэй барьцаалж байсан аж. Манай улсын төлөөлөгчид Мавританыг дэмжих бодолтой байсан боловч ЗХУ, зүүн Европын бүлгийг дагаж түдгэлзэхээс өөр аргагүй болжээ. Энэ бол НҮБ-д элсээд тус улсын анхны өгсөн санал, дуу хоолой байлаа. Орой нь төлөөлөгчид байрандаа цуглараад:

- Жаахан билэг дэмбэрэлгүй юм болов уу даа хэмээн зовнин ярилцахад Д.Цэвэгмид:

- Бид чинь социалист орнуудаасаа салж санал өгөх эрхгүй тийм удирдамжтай шүү дээ хэмээн хэлж байжээ. Төлөөлөгчдийн гишүүн Урианхан Б.Жаргалсайхан: “Цэвэгмид бол Гадаад яамны нэгдүгээр орлогч сайд,

төлөөлөгчдийн тэргүүн, эрдэмтэн, зохиолч хүн байлаа. Тэрбээр албан тушаал, хэргэм зэргээ амтархаж, их зан гаргахгүй, ерийн сэхээтний хэв шинжит зүртэй, хүнтэй аль болохоор соёлтой харьцахыг хичээнэ. Гэхдээ өөрийн ажлын хариуцлагаас болж зарчмаа барих гээд заримдаа уян хатан нь дутна. Амралтын цагийн чөлөөтэй ярианд дуртайяа оролцох боловч улс төрийн шүүмжлэлтэй сэдвээс зайлсхийнэ” (7,167) хэмээн дурсан бичсэн байна.

Д.Цэвэгмид НҮБ-д улс орноо элсүүлэх их ажлыг бүтээгээд сэтгэл дүүрэн буцаж ирлээ. Энд тэнд уригдан уулзалт хийж, НҮБ-д элсэн үйл явцыг ярихын зэрэгцээ АНУ-ын хөгжлийн тухай өөрийн эрхгүй зарим баримт дурьджээ. Гэтэл Цэвэгмид хөрөнгөтөн орныг магтан сайшааж ярьж байна гэсэн яриа гарч эхлэв. Эл яриа тэр дороо л МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчоонд хүрчээ. Түүнийг Улс төрийн Товчооны хуралд дуудав. Хуралдааны танхимын хүлээлгийн өрөөнд асуудал оруулах хэд хэдэн удирдах ажилтнууд сууж байв. Тэгэж байтал Цэвэгмидийг дуудав. Зарим гишүүд АНУ-ын хөгжлийн тухай, энэ талаар сурталчилгаанд юу ярьсан тухай асуугаад, асуудалд ангич, намч байр суурь баримтлаагүй, улс төрийн боловсрол сул дорой гэж зэмлэн, Гадаад явдлын яамны I орлогч сайдаас халжээ. Тэндээс гарахад үүдэнд хүлээж байсан нөхөд нь юу болов, яав гэж асуухад тэрбээр:

- Юм үзэж, нүд тайлаагүйн харгай гарав аа хө гэж хэлчихээд яваад өгсөн гэдэг. Д.Цэвэгмидийг 1962 онд БНМАУ-аас БНХАУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар томилжээ. Энэ үе бол хоёр орны харилцаанд ан цав сууж, тун ээдрээтэй болсон цаг байв. 1963 оны XII сард хуралдсан МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал “Хятадын коммунист намын удирдагчдаас дэлхийн коммунист хөдөлгөөнд гаргаж байгаа зөрөлдөөн ба МАХН-ын бодлогын тухай” тогтоол гаргаж, “... агуу их Хятадын ард түмэнтэй найрамдал, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх бодлого туйлбартай явуулсаар байгаа МАХН, хятадын удирдагчдаас элдэв төрлийн даралт шахалт үзүүлэх замаар марксизмд харш шугамаа манай намд тулган хүлээлгэх, манай намыг дэлхийн коммунист хөдөлгөөнөөс ба түүний шилдэг манлай хүч-ЗХУКН-аас таслах, түүнчлэн манай ард түмнийг агуу их зөвлөлтийн ард түмэн болон социалист бусад орны ард түмэнтэй мөнхийн холбоо, найрамдалтай байх ганц зөв замаас нь гаргах гэсэн үл бүтэх арчаагүй оролдлогыг эрс шийдвэртэй няцаан буруушааж байна” (8,50) гэж онцлон тэмдэглэсэн байна.

Энэ нь тухайн үеийн монголын удирдагчид хэт нэг талыг барьж, асч байгаа гал дээр тос нэмсэн хэрэг байлаа.

БНХАУ-д “соёлын хувьсгал” гэгч газар авч, БНМАУ-ын эсрэг компани хүчтэй дэгдсэн байна. Ийм хүнд үед Элчин сайд Д.Цэвэгмид хоёр орны уламжлалт харилцааг тасалчихгүй байх талаар тун хүлээц тэвчээртэй хандаж, ухаалаг байр суурь барьж байсан аж. Түүнийг 1962-1967 онд Элчин сайдаар ажиллах үед БНМАУ-ын Элчин сайдын яам руу халдах, машиныг нь шатаах зэргээр дипломат ёсны хэм хэмжээг ноцтой зөрчиж, улаан хамгаалагчид дураараа авирлаж байжээ. Улаан хамгаалагчид манай Элчин сайдын яамны байр руу дайрч, Элчин сайдын албан тасалгаанд орж ирэн, ханан дээр “Ревизионист” гэх мэт бичиг эрээчиж байхад Д.Цэвэгмид сайд юу ч болоогүй юм шиг тайван ажиллаж байсан гэдэг. Түүний гаргасан зориг тэвчээр, хүлээцтэй хандлагыг тэр үед Элчин сайдын яаманд I нарийн бичгийн даргаар ажиллаж байсан академич Ч.Далай багш дурсан ярьдаг.

Төр, засгийн удирдах албанаа Цэвэгмид багш 1967 онд Хятадаас буцаж ирээд МУИС-ийн ректороор дахин томилогдсон байна. Удалгүй Ардын Их Хурлын долоо дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганаар Ардын Их Хурлын даргаар сонгогдсон юм. Тэрбээр 1969-1973 он хүртэл уг сонгуульт албыг гүйцэтгэж байжээ. Тэрбээр 1967-1972 онд МУИС-ийн ректороор ажиллах хугацаандаа тус сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын чанарыг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэх асуудалд онцгой анхаарал тавьжээ. 1969 онд МУИС-ийн инженер-техникийн факультетуудыг нэгтгэсэн Политехникийн дээд сургуулийг тус сургуулийн бүрэлдэхүүнд байгуулсан юм.

• 1970-аад оноос МУИС-ийн хөгжил улам эрчимжжээ. Учир нь тус сургууль манай орны олсн дээд сургуулийг өөрөөсөө төрүүлэн, дэлхийн олон орны үндэсний их сургуулийн зиндаанд дөхөж очиж, жам ёсны голдрилоороо хөгжих замд баттай оржээ. Ийм ч учраас 1971 онд Ардын хувьсгалын 50 жилийн ойгоор МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчид, МҮЭ-ийн Төв Зөвлөл, МХЗЭ-ийн Төв Хорооны үүрд хадгалах туг дипломоор МУИС-ийг шагнасан бүлгээ. 1972 оны XII сард МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс “Дээд сургуулиар мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх системийг улам боловсронгуй болгох арга хэмжээний тухай” тогтоол гаргажээ. Эл тогтоолд “мэргэжлийн гүн бат мэдлэг эзэмшсэн, нийгэм улс төрийн ажлын дадлага бүхий, өндөр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх явдал дээд сургууль, түүний профессор багш нарын эрхэм

хүндэт үүрэг мөн” гэж заагаад сургалт, судалгааны ажлын чанарыг сайжруулах, багш нарын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авсан билээ.

Дээрх заалт шийдвэрийн дагуу МУИС-ийн сургалтын агуулга, хэлбэрийг сайжруулах талаар олон чухал ахиц гарсан юм. Юуны өмнө сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүдтэй ойртуулан сайжруулах арга хэмжээ авсан байна. Мөн энэ чиглэлээр сургалтын технологи, арга зүйг боловсронгуй болгох алхам хийжээ. Энэ бүхэнд профессор Д.Цэвэгмидийн хичээл зүтгэл, удирдах зөвөргүү зөөлөн арга барил томоохон үүрэг гүйцэтгэжээ.

Сайхь профессор мэргэжлийн ангид “Сээр нуруутны судлал”-аар хичээлээ заасаар байсан юм. Цэвэгмид багш хичээлийг сэтгэлд хүрч, нүдэнд харагдтал дүрсэлж, ухааны сүвийг нэвт шувт нээгдтэл заадаг, сээр нуруутны дүр төрх, хөдөлгөөн, араншин, жигүүртэн шувуудын уран жиргээ, халин халин нисэх хан жигүүрийг нүдэнд буутал үгээр зурж, уг асуудлаа шинжлэх ухааны сүүлийн үеийн ололтын өндөр түвшинд ойлгуулдагсан гэж шавь нар нь бахархан дурсдаг.

Цэвэгмид багш шавь нарынхаа ой тойнд буутал сургаалаа хайрладаг, үнэн үгээ зүрхэнд шивж чаддаг сурган хүмүүжүүлэгч байсан бүлгээ. Нэг жишээ татъя. 1971 онд би МУИС-ийн түүхийн анги төгссөн юм. Энэ жил МУИС-ийн 26 дахь төгсөлт болж, 600 гаруй оюутан диплом гардан авсан билээ. Төгсөлтийн хурал дээр МУИС-ийн ректор, профессор Д.Цэвэгмид багш үг хэлэхдээ: “Ахмад нь эхлээд залуугаа дагуулдаг, дараа нь ахмадын халаанд залуу нь зогсдог нь жам ёс юм. Гагцхүү ахмад үеийн халааг нэр төртэй залгамжилсанаар түүх урагш ахидаг тавилантай билээ. Та нарыг бид өөрсдийн шавь нар гэж үзэж байна. Дээд мэргэжилтэй олон шавь нартайдаа бид баяртай байдаг. Улс эх орондоо их үйл хэргийг бүтээх, сайхан ирээдүйтэй мэргэжилтнийг бэлтгэх үлэмж хүндэт үүрэг хариуцлага хүлээж ажилладаг. Манай багш нар Та бүхнийг үйлдвэрлэлд хэрэглэдэг томъёогоор бол өөрсдийн хөдөлмөрийн бодит бүтээл гэж бахдан харж байна.

Та нар анх тус Их сургуульд элсэн орж байх үедээ дөнгөж дунд сургууль төгсгөсөн хүүхдүүд байж билээ. Одоо мэргэжилтэн боллоо, эрдмийг өвөрлөж, эрийн цээнд хүрлээ. Хун цэнгийн дэгдээхэй өд сөдөө ургахад гурван далайг гатлана, хулан тахийн унага хумсан туурайгаа хатахад гурван говийг туулна гэж манай монголын эртний үг бий. Дэгдээхэй байсан цаг өнгөрлөө. Одоо Та нар

өслөө, өд сөд гүйцлээ, үүрээ орхин нисч, эх орныхоо уудам цэлмэг агаараар элин хальж төр түмэндээ тустай үйлийг бүтээх чин зоригийг барьлаа" (9) гэх мэтээр ярихад МУИС-ийн "А" клубт ялаа нисэх ч чимээ дуулдахаар нам гүм болж, ихэнх төгсөгчдийн самсаа шархирч, аньсага норж байсан юм. Тэрбээр жинхэнэ ясны багш хүн байлаа.

1972 онд Д.Цэвэгмидийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч даргаар томилжээ. Тэрбээр нуруундаа нэгэн том сургуулийн ачаа бус, нийт улсын боловсрол, шинжлэх ухаан, соёл, эрүүлийг хамгаалахын бүх ачааг үүрэх болов.

Д.Цэвэгмид Сайд нарын Зөвлөлийн орлогч даргын албыг 1987 он хүртэл 16 жил хашихдаа 1973-1980 онд Улсын дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролын хорооны дарга, 1980-1984 онд Соёлын яамны сайдаар хавсран ажиллажээ.

Д.Цэвэгмид ардын боловсрол, эрүүлийг хамгаалах, соёл, шинжлэх ухаан, биеийн талаар, спортын салбарыг хариуцан ажиллахдаа уг чиглэлүүдээр МАХН-ын Төв Хороо, Сайд нарын зөвлөлд олон асуудал боловсруулан оруулж, тогтоол, шийдвэр гаргуулж байв. Түүний үр дүнд манай орны насанд хүрсэн таван хүний нэг нь дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой болжээ. Эрүүлийг хамгаалах харьцангуй найдвартай тогтолцоо бий болж, хүн ам эрүүлжсэн байна. Үндэсний соёлын үнэт зүйлсийг дэлхий дахины сонгодог соёлын үнэт зүйлстэй хослуулан амжилттай хөгжүүлж, урлаг, утга зохиолын сор болсон олон бүтээлүүд гарч байв. Шинжлэх ухааны суурь болон хавсрага судалгаа хөгжжээ. Гэхдээ төр, нийгмийн зүтгэлтэн бол тухайн оршин тогтнож буй нийгмийн тогтолцооны бүтээгдэхүүн л байдаг. Түүнийг ажил хариуцаж байх үед "Эрүүлийг хамгаалах байгууллагын ажлын тухай" (1973), "Биеийн тамир, спортын эвлэлийн төв зөвлөлийн удирдлагын ажилд оршиж байсан ноцтой дутагдлын тухай" (1978) МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны тогтоол гарч, Б.Дэмбэрэл, Ш.Магван, Д.Цэрэндаш зэрэг хүмүүсийг хилсээр хохирооход хүрч байжээ. Мөн А.И.Филатовад "БНМАУ-ын Соёлын гавъяат зүтгэлтэн" цол олгох саналыг Намын Төв Хорооны Улс төрийн Товчоонд оруулж байсан байна. Ийм учраас МАХН-ын Төв Хорооны III бүгд хуралд (1990.VII.1) оруулсан "Ю.Цэдэнбалыг тойрон хүрээлэгчдийн үйл ажиллагаанд өгөх улс төрийн дүгнэлтийн тухай" комиссын илтгэлд: "Ю.Цэдэнбалтай нэлээд хугацаагаар хамт ажиллан нам, олон нийт, хууль хяналтын байгууллагыг удирдах, эдийн засаг, нийгэм, улс төрийн бодлого, гадаад эдийн засгийн харилцааны асуудлыг боловсруулах, хэрэгжүүлэхэд биечлэн оролцож ирэхдээ ... нийтлэг

дутагдлын нэлээдтэй нь ямар нэг хэмжээгээр холбогдолтой гэж үзэж П.Дамдин, Ц.Намсрай, Д.Цэвэгмид, М.Пэлжээ, М.Даш, Ч.Сүрэн нарыг намаас сануулж зэмлэх саналтай байна” (10) гэж тэмдэглэжээ. Хүн тус бүрээр гаргасан дүгнэлтэд Д.Цэвэгмидийг “Ю.Цэдэнбалаас явуулж байсан нэг хүний захиран тушаах хүнд сурталт системийг баримтлагчийн нэг” (5) гэж дүгнэжээ.

Цэвэгмид ба Филатова. Зарим ном зохиолд Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Д.Майдар, Д.Цэвэгмид, Төв Хорооны нарийн бичгийн дарга Г.Адъяа нар “хатан хааны” (А.И.Филатова Ж.Б) ивээлд байв (11,196) гэж бичсэн нь бий. Гэхдээ ивээлд багтахад учир начиртай аж. Цэвэгмид багш дээр дурьдсан комиссынхантай ярилцахдаа: 1980 онд хэрхэн Соёлын яамны сайд болсон, А.И.Филатовагийн арга эвийг олох гэж хэрхэн зовж байсан тухайгаа илэн далангүй хуучилсан бүлгээ.

1980 оны II сарын 1-нд Ю.Цэдэнбал дарга түүнийг дууджээ. Тэрбээр:

- Чамд Соёлын яамны сайдын албыг хавсран ажиллуулна гэв. Цэвэгмид:

- Би тэртэй, тэргүй Соёлын яамыг хариуцдаг шүү дээ. Сайд болох боломжгүй. Дээд боловсролын хорооны даргыг хавсран гүйцэтгэж байгаа шүү дээ, дарга аа гэхэд дарга:

- Тэр ажилд чинь өөр хүн тавъя. Чи саналаа хэл хэмээхүйд Цэвэгмид:

- Үгүй, дарга аа, би Соёлын яамны сайдын ажлыг хийж чадахгүй, мэдлэг чадвар ч хүрэхгүй гэжээ. Цэдэнбал дарга нэлээд шаргуу, уурлах маягтай шаардаж байснаа зөөлөрч:

- Цаад авгай чинь хүнтэй таарахгүй юм. Чи л нэг эвийг нь олоод байх болов уу гэж гуйж учирласан байдалтай хэлжээ. Тэгээд МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны хуралдаанд асуудал оруулан, Д.Цэвэгмидийг Соёлын яамны сайдаар батлуулжээ. Чингээд Цэвэгмид Соёлын яамны сайдаар дөрвөн жил хавсран ажиллажээ. А.И.Филатова Хүүхдийн төлөө фондын дарга боловч, соёл, урлагийн бүхий л ажилд оролцоно. Төрийн концерт, баяр ёслолын арга хэмжээг авгай гол төлөв дэглэнэ. Арга хэмжээний бэлтгэлийн явцад Цэвэгмид болон Намын Төв Хорооны соёлын салбар хариуцсан хүмүүс, түүнчлэн сайд нарыг дуудаж, элдэв зүйлийг тулгаж, шаардаж загнинана. Сэтгэлд таараагүй нэртэй жүжигчин, дуучдыг хөдөө хөөж явуул гэж Сайд нарын Зөвлөлийн орлогч даргыг шаардана. Тэр ч байтугай нэг удаа Буриадын соёл, урлагийн төлөөлөгчид ирэх үед Цэвэгмид даргыг авгай учир дүрсгүй загинахад тэрбээр байдлыг учирлажээ. А.И.Филатова:

- Нет, в Гоби гэж хэлжээ. Тэр ярианы үед байсан Буриадын соёлын зүтгэлтэн Бадиев хожим уулзаад:

- Анастасия Ивановна таныг говь руу цөлнө гээд байсан цөлөөгүй юу. Буриад хүн болохоороо Буриад руу очъё гэж хэлэхэд тань баярлаж байсан шүү гэж хэлж байжээ.

Авгай Соёлын яамны ажилд байнга оролцоно, тэр бүхнийг Цэвэгмид дарга яаж ийгээд л аргацааж байжээ. Жишээ нь: Манай урлагийн томчуул-дуучин Жаргалсайхан, удирдаач Чулуун, хөгжмийн зохиолч Лувсаншарав зэрэг олон хүний хийсэн зүйл таалагдахгүй болохоор "Хөдөө явуул, цөл" гэж шаарддаг байжээ. Чингээд Цэвэгмид Соёлын яамны I орлогч сайд Баатарцогтод хандаж:

- Чамаас дээр дурьдсан хүмүүсийн тухай асууж магадгүй. Тушаал төлөвлөж байна гээрэй. Дахиж асуувал гарын үсэг зуруулах гэж байна, Төв Хороонд танилцуулж байна гэх мэтээр аргалаад байгаарай гэдэг байжээ. Нэг өдөр авгай их л сайхан ааштай. Жаргалсайханыг хөдөө явуулаагүй чинь болж, "Шидэт ваар"-д сайн тоглолоо гэж хэлж байжээ.

Бас авгайн ямар зан нь хөдөлсөн юм бүү мэд Цэвэгмид даргыг дуудаж:

- Норовбанзадыг концертонд бүү тоглуул. Тэр кукла шиг инээхийг мэддэггүй, муухай хүүхэн гэхэд Цэвэгмид:

- Норовбанзад чинь ард түмэндээ их хэр хүндтэй уртын дуучин шүү дээ гэжээ. А.И.Филатова:

- Тэр хамаагүй, түүнийг нэн даруй хөдөө хөөж явуулахгүй бол чамайг хар гэрт хийнэ дээ хэмээн заналтай загшинажээ. Ю.Цэдэнбалыг тойрон хүрээлэгчдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх комиссынхонтой уулзахдаа Д.Цэвэгмид абугай энэ мэт олон зүйлийг ярьсан билээ (5).

Урлагийн гавъяат зүтгэлтэн Л.Эрдэнэбулгантай нэг удаа энэ тухай ярихад тэрбээр:

- Тэр бүгд үнэн. Би ч тэр зовлонг амссан хүн. Нэг удаа концертын асуудлаар А.И.Филатоватай яльгүй зөрсөн юм, зөрөх ч гэж дээ арай өөрөөр хийх тухай саналаа хэлсэн юм. Авгай намайг учиргүй загинасан. Хариуд нь би юу ч хэлээгүй, дуугүй л байв. Маргааш нь Цэвэгмид дарга намайг дуудсан. Тэрбээр:

- За, Эрдэнэбулган минь, асуудал буруугаар эргэх янзтай. Авгай чамайг хөдөө хөөж явуул гэсэн. Чи гурван сар бригад авч хөдөө явчих. Тэр хооронд цаад авгай чинь жаахан мартагнах байх гэж билээ. Ингээд би гурван сар хөдөө явж

байж “цагаадсан”. Цэвэгмид гуай ухаантай, том хүн тулдаа л авгайг аргалж байсан байх гэж ярьсан юм. “Хуур мэдэхгүй байж чихийг нь бүү мушги” гэдэг үг байдаг, хүнийг мэдэхгүй байж, юу юугүй буруутгах, дүн тавих бас хэцүү аж.

Төгсгөл. Улс эх орондоо нэгэн бүхэл бүтээн жарныг элтэл зүтгэсэн сайхь хүмүүн сүүлчийн 34 жилд нь МУИС-ийн ректор, Гадаад явдлын яамны орлогч сайд, Элчин сайд, Шинжлэх ухаан, дээд боловсролын хорооны дарга, Соёлын яамны сайд, Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга хэмээх төрийн дээд алба хашиж иржээ.

Д.Цэвэгмид МАХН-ын XIII-XIX их хуралд төлөөлөгч, XIII-XIX их хурлаас Намын Төв Хорооны орлогч гишүүн, XV-XIX их хурлаас Намын Төв Хорооны гишүүн, 1-5, 7-11 дэх удаагийн сонгуулиар АИХ-ын депутат, 7 дахь удаагийн сонгуулиар АИХ-ын даргаар сонгогдож байсан юм. Монгол улсын Төрийн шагналт, зохиолч Д.Нямаа: “Ажил амьдралын баялаг туршлагатай, хашир, нямбай, ноён нуруутай, тэмдэглэл нарийн хөтөлдөг, уурлахгүй байж чаддаг, хүн болгонтой халуун дотно инээмсэглэн мэндэлдэг, салж явахдаа гар барьж ямар нэг ерөөлийн аятайхан үг хэлдэг зэрэг содон чанар нь надад юуны түрүүнд анзаарагдаж байв. Цэвэгмид гуай Монгол эх орноороо төдийгүй дэлхийг хэдэнтээ тойрч хөндлөн гулд аялжээ. 1929 оноос эрдмийн моринд дөрөөлж Улаанбаатар, Дөрвөд аймаг, Баянтүмэн, Алтайн цаадахь говь, Москва, Берлин, Нью-Йорк, Токио, Гавана, Бээжин, Жакарта, Рангун, Дели, Бандунг гээд явсан суусныг нь тоолоход барагдахааргүй. Туулсан зам нь урт, үзсэн дуулсан нь их ийм хүн...” (1,4) хэмээн бичжээ.

Тийм ээ. Энэ хүн Монголд төдийгүй, олон улсад нэрд гарсан хүн. Иймд түүнийг Дэлхийн энх тайвны зөвлөлийн гишүүнээр сонгож, 1969 онд Жолио-Кюриин алтан медалиар шагнаж байв. 1942 он “Гавъяат багш” цол бий болгон, эл цолыг хэд хэдэн хүнд хүртээсний нэг нь Д.Цэвэгмид багш байлаа. Ийм учраас тэрбээр Монголын ууган гавъяат багш нарын нэг юм. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт эрдэмтэн зохиолч Л.Түдэв: “... Цэвэгмид гуай зохиолч, эрдэмтэн, дипломат, нийгмийн зүтгэлтэн, сурган хүмүүжүүлэгч багш хүн бөгөөд эдгээр олон талтай үйл ажиллагааных нь дотроос хамгийн ахмад бөгөөд сэтгэлийн гүнд шингэсэн нь багш юм” (1,113) гэж үнэлжээ.

Боловсрол, шинжлэх ухааны үйл хэрэгт оруулсан Д.Цэвэгмидийн хувь нэмрийг нь үнэлж, 1961 онд ШУА анх байгуулахад сурвалжлагч гишүүнээр сонгож,

улмаар Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургууль, Берлиний Хумбольдтын их сургуулийн хүндэт докторт өргөмжлөгдөж байв.

БНМАУ-ыг НҮБ-д элсэхэд төлөөлөгч тэргүүлж, БНХАУ, Индонез, Бирм, Пакистан зэрэг улсуудад элчин сайд байсан дипломат ажиллагааг нь үнэлж, 1981 онд Онц бүрэн Эрхт элчин сайд цол хүртээжээ.

Төрийн өндөр албан тушаал хашиж байхдаа ч уран бүтээлийнхээ ажлыг орхиогүй юм. Үүнийг 1980-аад онд нийтлэгдсэн “Анхны багш”, “Ухаан далай номоос эхтэй” бүтээлүүдээс мэдэж болно.

Хийсэн бүтээсэн хүнийг атаархал, хорслын үр дагалдаж байдаг нь жам ёс мэт. 1960-аад онд:

Хувилгаан багшаа муулан байж шүлэгчин болсон Цэвэгмид гуай

Хулгана зурмаа өвчин байж эрдэмтэн болсон Цэвэгмид гуай

Оюутан, сурагчдаа худалдан байж профессор болсон Цэвэгмид гуай

Худал үнэн хэлж байж дипломат болсон Цэвэгмид гуай (12) хэмээх үг гарсныг МАХН-ын Төв Хорооны VI бүгд хурал (1964) дээр Ц.Лоохууз тэмдэглэсэн байдаг. Энэхүү шог хошин үгэнд шүүмжилсэн ч юм шиг, түүний олон талт ажиллагааг сайшаасан ч юм шиг хоёрдмол утга буй.

Яаж ч үзлээ гэсэн Дондогийн Цэвэгмид хэмээх нэр Монгол улсынхаа төлөө гэсэн хичээнгүй зүтгэл, үр бүтээлээрээ монголын ард түмэн, түмэн олон шавь нарынхаа сэтгэлд мөнхрөн үлджээ.

Abstract: This article states about Mongolian socio-political figure, scientist, written Tsevegmid Dondog's life and works based on his memories and reminiscences and archive funds.

Эшлэл, зүүлт

1. Д.Цэвэгмид. Эргэн санахад (Дурсамж, тэмдэглэл). УБ., 2005
2. Монгол Ардын Хувьсгалт Намын Онц их хурал (1990 оны IV сарын 10-13). УБ, 1990
3. Х.Зандраабайдий “Заяа дутсан бурхад” УБ, 2001
4. Ц.Дамдинсүрэн “Дорнод талд” (1968) дурсамжаас
5. Ю.Цэдэнбалыг тойрон хүрээлэгчдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх комиссын материал. МАХН-ын дотоод архив
6. Монгол улсын их сургуулийн түүхийн товчоон. УБ., 2002

7. Урианхан Б.Жаргалсайхан. Алаг жарны бодрол. УБ., 2001
8. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. III дэвтэр. УБ, 1970
9. "Урлаг утга зохиол" сонин. 1971. VII.2. №27
10. Ю.Цэдэнбалыг тойрон хүрээлэгчдийн үйл ажиллагаанд өгөх улс төрийн дүгнэлт. "Үнэн" сонин. 1990.VI.30 №155
11. Баабар. Монголчууд. Нүүдэл, суудал. 4. УБ. 2006
12. МАХН-ын архив. Ф-4, Д-28, хн-2(в)